



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 81

Мандалговь

**Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.6 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 11,945,082 /арван нэгэн сая есөн зуун дөчин таван мянга наян хоёр/ төгрөгийн балансын үнэтэй 5,112,811 /таван сая нэг зуун арван хоёр мянга найман зуун арван нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /Ц.Ганзориг/-т дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах


2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



ДАРГА С.СҮХБААТАР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дүгээр сарын  
02 өдрийн 8/1 тогтоолын нэгдүгээр хавсралт



Акталж данснаас хасах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдгэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
1	Цахилгаан машины барилга	2012.11.01	6,015,072	1	6,015,072	902,261	5,112,811	Зориулалтын дагуу ашиглах боломжгүй, дээрээс ус нэвтэрч тоос шороо задгайрсан
2	Явган хүний замын гэрэл	2014.12.31	18,000	60	1,080,000	1,080,000	0	Кабелийн утас шатсан, гэрлийн ламп шатсан
3	Гэрлийн шон толгойт	2012.11.01	35,145	138	4,850,010	4,850,010	0	Кабелийн утас буудсан, гэрлийн толгоы суларч засаж сэлбэх боломжгүй болсон
	Нийт дүн				11,945,082 /арван нэгэн сая есөн зуун дөчин таван мянга наян хоёр/	6,832,271 /зургаан сая найман зуун гучин хоёр мянга хоёр зуун далан нэг/	5,112,811 /таван сая нэг зуун арван хоёр мянга найман зуун арван нэг	